



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар A/718

Арвайхээр

Буцалтгүй тусламж олгох тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 1 дүгээр багийн иргэн Доржпалам овогтой Буянтогтохын ар гэрт нь гачигдал гарч аймгийн Засаг даргад тусламж хүсч өргөдөл ирүүлсэн тул 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, мөн сумын 10 дугаар багийн иргэн Совд овогтой Ёндонпэрэнлэйн үхэрнүүд шүлхий өвчнөөр устгуулсан тул нөхөн олговорт 1000000 (нэг сая) төгрөгийг тус тус олгосугай.

2. Нийт 2500000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101558